

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **90.6** хувьтай байна.

Гурав. Үнэлэлт.

3.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 90.6 хувьтай бөгөөд 43 ажлын хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
43	90.6	29	6	4	3	1	-	-

3.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц:

Эрхзүйн актын нэр	Зүйл, заалт	Хэрэгжилт (хувиар)	Үүнээс (хувиар)				Хугацаа болоогүй
			100	70	30	0	
Улсын Их хурлын Байнгын хорооны тогтоол	1	100.0	1	-	-	-	-
Улсын Их хурлын тогтоол	5	60.0	2	1	1	1	-
Засгийн газрын тогтоол	3	90.0	2	1	-	-	-
Улсын Их хурлын Байнгын хорооны тогтоол	1	100.0	1	-	-	-	-
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	65.0	1	-	1	-	-
Засгийн газрын албан даалгавар	3	30.0	-	-	3	-	-

Дүн	15	66.0	7	2	5	1	-
-----	----	------	---	---	---	---	---

3.3 Зам, тээврийн сайдын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
4	82.5	3	-	1	-	-

3.4 ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
1	70.0	-	1	-	-	-

3.5 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
				100	90	70	50	30	0		
1	Төсөв, гүйцэтгэл	14	85.5	6	1	-	1	1	-	-	5
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	95.0	3	3	-	-	-	-	-	-
3	Бусад	8	98.3	5	1	-	-	-	-	-	2
Дүн		28	91.9	14	5	-	1	1	-	-	7

3.6 Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжилт-ийн дундаж хувь	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Үүнээс /хувиар/				
				100	70	30	0	Хамааралгүй
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	53.7	10	3	1	2	2	2
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	50.00	6	3	-	-	3	-
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх	68.7	15	9	1	2	3	-

	мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	100.0	2	2	-	-	-	-
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	85.7	13	5	1	1	-	6
Дүн		67.4	46	22	3	5	8	8

Дөрөв. Дүгнэлт:

I. Төлөвлөлтийн байдал

1. “ТТЗ” ХХК-ний 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний хугацааг улирал тус бүрээр төлөвлөөгүй байна. Тухайлбал: 1.2-1.5, 2.1-2.4, 3.1, 3.2 гэх мэт.

II. Хэрэгжилтийн байдал:

1. “Тавантолгой төмөр зам” ХХК 2024 онд үйл ажиллагаандаа нийт 137 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласнаас жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй 75, 90 хувийн хэрэгжилттэй 11, 70 хувийн хэрэгжилттэй 10, 50 хувийн хэрэгжилттэй 4, 30 хувийн хэрэгжилттэй 13, тасарсан буюу хэрэгжүүлээгүй 9, хамааралгүй болон оруулах мэдээлэлгүй 15 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар **80.2** хувьтай байна.

2. Тус компанийн төмөр замын суурь бүтцээр 4,008.55 мян.тонн ачаа тээвэрлэснээс Тавантолгой-Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд 1,692.63 мян.тонн, Тавантолгой-Цогтцэций-Тавантолгой чиглэлд 2,315.92 мян.тонн ачааг тус тус тээвэрлэж, өнгөрсөн оны мөн үеийн тээвэрлэлтийн хэмжээтэй харьцуулахад 218 хувийн өсөлттэй гарч байгаа боловч 2024 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 70 хувийн хэрэгжилттэй байна.

3. “ТТЗ” ХХК 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд тайлант хугацаанд бусад үйл ажиллагаанаас нэмэлт орлого бүрдүүлснээр цэвэр ашгийн төлөвлөгөөг 180%-иар давуулан биелүүлсэн.

4. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5. Тайлант хугацаанд хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тухай бүр шинэчилж, холбогдох журамд заасан тэмдэгтэд багтаан тайлагнаагүй, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

6. Тус байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:

- Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан өөрийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бүрэн тусгаж, зорилтот түвшнийг ижил төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллах;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан боловч хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарч, төлөвлөгөөний биелэлттэй холбоотой төлөвлөгөө түүний хэрэгжилт, холбогдох бусад баримт бичгийг хавсралтаар гарган ирүүлж хэвших;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход анхаарч байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;
- Шилэн дансанд байршуулдаг мэдээллийг мэдээлэх ажлыг шуурхай гүйцэтгэж, мэдээллийг тогтоосон хугацаанд тухай бүр нь оруулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

- Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж хоёр мянган тэмдэгтэд багтаан ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан, зөв бичгийн дүрмийн алдаагүй тайлагнаж хэвших;
- Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд анхаарч, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчилгүй санал, дүгнэлт авч, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч удирдлагын хяналтыг сайжруулах;
3. Технологийн горимуудыг боловсруулж батлуулах, гэрчилгээ авах зэрэг хөрөнгө санхүүжилт шаардагдахгүй хэрэгжүүлэх боломжтой ажлыг яаралтай дуусгах;
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт болон Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж ажиллах;
5. Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;
6. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР